



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/224

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотоос тус аймаг руу нэвтрэх иргэдийн "ПСР" шинжилгээ болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж Цэнхэрмандал сумын "Дэлүүн болдог" постод энэ оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 25 хоногийн хугацаанд ажиллах 11 алба хаагчийн хоол, холбоо, байрны болон автомашины шатах тослох материалын зардлыг хавсралтаар баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 6,947,500 (зургаан сая есөн зуун дөчин долоон мянга таван зуу) төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011458

05 Аймгийн Засаг даргын 2021 оны  
дугаар сарын 07 өдрийн 1/2021  
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тусоцоо

| Байгууллагын нэр | Шатахуун       | Байр           | Хоол             | Холбоо, бичиг хэрэг | Дүн              |
|------------------|----------------|----------------|------------------|---------------------|------------------|
| Цагдаагийн газар | 387,500        | 900,000        | 5,500,000        | 160,000             | 6,947,500        |
| Нийт             | <b>387,500</b> | <b>900,000</b> | <b>5,500,000</b> | <b>160,000</b>      | <b>6,947,500</b> |